



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2025/11/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Н.Мөнхнасан Цахим хаяг: munkhnasann@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гуудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.03.25 № 4-6/351

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
О.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хөвсгөл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагч, сан, тусгай дансны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 82.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон материаллаг байдлын түүшингээс давсан байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сумын татварын болон татварын бус орлого 3,289.3 сая төгрөгөөс орон нутгийн төсөвт байгууллагуудад 1,204.2 сая төгрөгийн, санхүүжилтийг тус тус олгож давсан орлого 2,085.1 сая төгрөгийг аймгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

1. Орон нутгийн хөгжлийн сангаас 4.3 сая төгрөгийг багш ажилчдын 4 айлын орон сууцны халаалт, цэвэр бохир усны холболт хийх ажлын зураг төсвийг боловсруулах ажлыг санхүүжүүлсэн байна. .



2.ОНХС-ийн өмнөх оны дутуу хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг 2024 оны сумын ИТХ-аар батлуулаагүй байна. Батлагдаагүй 3-н төсөл арга хэмжээний санхүүжилт болох 28.4 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжүүлсэн байна.

3.Тус сумын ИТХ-ын "Өрөөний дотор засвар хийх" ажил гүйцэтгэх гэрээг иргэн С.Оюунбаттай 2024.11.22-ны өдөр байгуулж, ажлын хөлсөнд 19.9 сая төгрөг шилжүүлж, засварын ажил хийгдэж эхлээгүй, ажлыг хүлээж аваагүй байхад шууд зардалд хаасан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд сумын түүхт 100 жилийн ой болсонтой холбогдуулан төсвийн харилцах дансаар дамжуулан хандив төвлөрүүлээгүй бөгөөд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас үндсэн хөрөнгө, бараа материал, мөнгөн хөрөнгө зэрэг хандив бүртгэгдээгүй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээлэл хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

		/мянган төгрөг/	
Код	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>540,242.10</b>	<b>559,076.60</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>232,256.80</b>	<b>149,130.80</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>113,200.60</b>	<b>211,580.60</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>194,784.70</b>	<b>198,365.30</b>
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,728,368.90</b>	<b>2,865,408.40</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,728,368.90</b>	<b>2,865,408.40</b>
39200	Биет хөрөнгө	2,638,576.30	2,776,010.40
39300	Биет бус хөрөнгө	89,792.70	89,398.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,268,611.00</b>	<b>3,424,485.00</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>102,771.90</b>	<b>104,885.60</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>102,771.90</b>	<b>104,885.60</b>
41300	Өглөг	102,771.90	104,885.60
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,165,839.10</b>	<b>3,319,599.40</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,165,839.10</b>	<b>3,319,599.40</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,409,823.10	1,409,823.10
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,595,579.60</b>	<b>1,749,339.90</b>
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	160,436.40	160,436.40
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,268,611.00</b>	<b>3,424,485.00</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

		/мянган төгрөг/	
Код	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,813,972.10</b>	<b>6,385,256.10</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,620,474.20</b>	<b>3,284,089.20</b>
110	Орлогын албан татвар	1,505,410.30	3,145,529.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,505,410.30	3,145,529.50
113	Хөрөнгийн албан татвар	19,314.30	40,959.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	95,749.60	97,600.80
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,124,829.20</b>	<b>557,991.80</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,124,829.20	557,991.80
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,068,668.70</b>	<b>2,543,175.10</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,687,468.90</b>	<b>6,090,729.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,687,468.90</b>	<b>6,090,729.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,592,747.40</b>	<b>2,128,835.50</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	495,317.60	830,467.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,193.80	104,287.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,635.60	307,930.90
2104	Хангамж, бараа материалын зардал	66,467.00	85,190.90
2105	Нормативт зардал	2,444.70	15,261.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,181.50	53,754.90
2107	Томилолт, зочны зардал	7,462.80	15,520.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,857.80	46,728.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	877,186.50	669,692.20
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,094,721.40</b>	<b>3,961,894.10</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,126,503.20</b>	<b>294,526.50</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,567.80</b>	<b>153,873.80</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>1,122,935.50</b>	<b>140,652.70</b>

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Тайлангийн үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,043,103.30</b>	<b>2,043,103.30</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-10,267.50	-10,267.50
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,032,835.80	2,032,835.80
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	10,067.80	10,067.80
9	Тайлант үеийн үр дүн	1,122,935.50	1,122,935.50
10	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,165,839.10</b>	<b>3,165,839.10</b>
11	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>3,165,839.10</b>	<b>3,165,839.10</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	13,107.60	13,107.60
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,178,946.70	3,178,946.70
19	Тайлант үеийн үр дүн	140,652.70	140,652.70
20	<b>2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>3,319,599.40</b>	<b>3,319,599.40</b>

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Код	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөг/	
		Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,768,744.40</b>	<b>5,937,448.40</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,620,474.20</b>	<b>3,284,089.20</b>
110	Орлогын албан татвар	1,505,410.30	3,095,126.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,505,410.30	3,095,126.00
113	Хөрөнгийн албан татвар	19,314.30	91,362.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	95,749.60	97,600.80
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	26,074.20	26,982.70
1181	Газрын төлбөр	69,675.40	70,618.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>43,211.40</b>	<b>53,902.90</b>
120	Нийтлэг татварын бус орлого	43,211.40	53,902.90
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,105,058.80</b>	<b>2,599,456.30</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,772,898.20</b>	<b>6,007,994.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,772,898.20</b>	<b>6,007,994.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,468,971.20</b>	<b>2,014,086.70</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	495,438.70	830,706.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,330.40	104,024.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,201.00	307,930.90
2104	Хангамж, бараа материалын зардал	48,715.60	37,202.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,669.30	61,202.80
2107	Томилолт, зочны зардал	7,409.80	15,573.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,840.00	197,290.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	732,366.40	460,155.60
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,303,927.00</b>	<b>3,993,908.00</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>-4,153.90</b>	<b>-70,546.30</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>173,870.60</b>	<b>12,579.80</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>173,870.60</b>	<b>12,579.80</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	173,870.60	12,579.80
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-173,870.60</b>	<b>-12,579.80</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-178,024.40</b>	<b>-83,126.10</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	410,281.20	232,256.80
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	232,256.80	149,130.80

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөг					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	ЗГСУМС гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,467,791.30</b>	<b>2,243,146.47</b>	<b>1,301,692.59</b>	<b>821,853.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,467,791.30</b>	<b>2,243,146.47</b>	<b>1,301,692.59</b>	<b>821,853.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,785,485.50</b>	<b>1,565,316.36</b>	<b>1,286,998.59</b>	<b>158,717.77</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>884,100.90</b>	<b>829,281.47</b>	<b>829,281.47</b>	<b>1,000.00</b>
210101	Үндсэн цалин	411,666.00	419,757.21	419,757.21	0
210102	Нэмэгдэл	368,402.00	331,368.72	331,368.72	0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,242.50	47,058.16	47,058.16	0
210104	Урамшуулал	53,790.40	31,097.38	31,097.38	1,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>115,585.30</b>	<b>104,024.73</b>	<b>104,024.73</b>	<b>0</b>
210201	Тэтгэврийн даатгал	80,141.20	72,695.87	72,695.87	0
210202	Тэтгэмжийн даатгал	7,094.90	7,101.58	7,101.58	0
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,855.00	6,122.84	6,122.84	0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,772.10	1,766.10	1,766.10	0
210205	Эрүүл мэндийн даатгал	17,722.10	16,338.34	16,338.34	0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>366,455.50</b>	<b>307,930.91</b>	<b>42,315.57</b>	<b>265,615.34</b>
210301	Гэрэл, цахилгаан	32,508.50	23,550.61	23,550.61	0
210302	Түлш, халаалт	312,352.80	268,641.17	268,641.17	0
210303	Цэвэр, бохир ус	21,594.20	15,739.12	15,739.12	0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>37,925.50</b>	<b>36,282.87</b>	<b>36,282.87</b>	<b>0</b>
210401	Бичиг хэрэг	5,920.00	5,234.25	5,234.25	0
210402	Тээвэр, шатахуун	24,277.50	25,202.19	25,202.19	0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,534.00	4,047.94	4,047.94	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	394.00	0	0	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800.00	1,798.50	1,798.50	0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>85,672.40</b>	<b>73,192.65</b>	<b>60,490.22</b>	<b>12,702.43</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,250.00	9,589.60	9,589.60	0
210602	Тавилга	7,000.00	2,655.00	2,655.00	0
210604	Урсгал засвар	63,422.40	60,948.05	60,948.05	0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>13,504.60</b>	<b>9,633.50</b>	<b>9,633.50</b>	<b>0</b>
210702	Дотоод албан томилолт	13,504.60	9,633.50	9,633.50	0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>273,201.30</b>	<b>197,380.23</b>	<b>197,380.23</b>	<b>-120,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	271,448.30	196,109.08	196,109.08	-120,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	330.00	0	0	0
210803	Даатгалын үйлчилгээ	700.00	700.00	700.00	0

Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	327.00	285.31	285.31	0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	96.00	88.00	88.00	0
210807	Газрын төлбөр	300.00	197.84	197.84	0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,040.00</b>	<b>7,590.00</b>	<b>7,590.00</b>	<b>300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,500.00	5,000.00	5,000.00	300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,540.00	2,590.00	2,590.00	0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>682,305.80</b>	<b>677,830.11</b>	<b>14,694.00</b>	<b>663,136.11</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>666,905.80</b>	<b>663,136.11</b>	<b>0</b>	<b>663,136.11</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	666,905.80	663,136.11	663,136.11	0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>15,400.00</b>	<b>14,694.00</b>	<b>14,694.00</b>	<b>0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,400.00	14,694.00	14,694.00	0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,467,791.30</b>	<b>2,162,923.55</b>	<b>1,217,208.56</b>	<b>945,714.99</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>656,974.10</b>	<b>631,797.67</b>	<b>1,177,516.59</b>	<b>-545,718.92</b>
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	656,974.10	631,797.67	0	631,797.67
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,610,385.50</b>	<b>1,482,522.95</b>	<b>0</b>	<b>1,482,522.95</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,610,385.50	1,482,522.95	0	1,482,522.95
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>200,431.70</b>	<b>48,602.93</b>	<b>39,691.97</b>	<b>8,910.96</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.00	41,951.93	36,415.97	5,535.96
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,500.00	6,651.00	6,651.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	144,931.70	0	0	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	196,241.74	0	202,664.30
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	116,018.83	0	122,441.38
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>				
610001	Төсвийн байгууллага	2	2	0	2
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>28</b>	<b>28</b>	<b>0</b>	<b>28</b>
620001	Удирдах ажилтан	9	9	0	9
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11	0	11
620003	Үйлчлэх ажилтан	8	8	0	8
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>28</b>	<b>28</b>	<b>0</b>	<b>28</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11	0	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	10	0	10
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	0	7

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Зөрүү
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>458,446,270.32</b>	<b>458,446,270.32</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>458,446,270.32</b>	<b>458,446,270.32</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>431,757,603.00</b>	<b>431,757,603.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,425,250.00</b>	<b>1,425,250.01</b>
210104	Урамшуулал	1,425,250.00	1,425,250.01
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>919,243.00</b>	<b>919,243.01</b>
210401	Бичиг хэрэг	525,000.00	525,000.01
210402	Тээвэр, шатахуун	394,243.00	394,243.01
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.01</b>
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.01
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,940,000.00</b>	<b>5,940,000.01</b>
210701	Гадаад албан томилолт	0	0.01
210702	Дотоод албан томилолт	5,940,000.00	5,940,000.01
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>422,973,110.00</b>	<b>422,973,110.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	422,973,110.00	422,973,110.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,688,667.32</b>	<b>26,688,667.33</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>26,688,667.32</b>	<b>26,688,667.33</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	26,688,667.32	26,688,667.33
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>458,446,270.32</b>	<b>458,446,270.32</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>458,446,270.32</b>	<b>458,446,270.32</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	363,868,623.00	363,868,623.01
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	94,577,647.32	94,577,647.33

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

**Засаг Даргын Тамгын Газар**

Аудитаар нийт 49,547.2 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрснээс 15,161.0 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад бүрэн залруулж, залруулагдаагүй 5 зөрчилд 2 албан шаардлага, 3 зөвлөмж өгөв.

**Залруулсан алдаа:**

1. Байгууллагын нийт ажилчдын цалин, нэмэгдлийг payroll цалингийн системийн цалин хөлсний нэмэгдэлтэй тулгахад нийгмийн даатгалын шимтгэлийн 106,522.33 төгрөгийн өглөгийг тайлагнаагүй, тайлант хугацааны эцэст Татвар болон Нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, цалинтай холбоотой өр авлагагүй тайлагнасан байна. Мөн цалингийн зардалд 99,000 төгрөгийн бараа материалыг хааж бүртгэснийг залруулав.
2. Түлш халаалтын зардлаас цэвэр бохир усны зардлыг зарцуулсан хэдий ч үр дүнгийн тайланд жинхэнэ зарлагаар тайлагнаагүй байна
3. Тус байгууллага нь тайлант хугацаанд ОНХС-аас ажилчдын орон сууцны дулаан, цэвэр бохир усны шугамын ажилд 4.4 сая төгрөгийг зарцуулсан ба тус өглөгийг санхүүгийн тайланд тусгаж залруулсан.
4. Тус байгууллага нь малын нас дэвшилтийн орлогыг санхүүгийн үр дүнгийн тайланд нэмэгдүүлсэн дүнгээр бүртгэж тайлагнасныг залруулав.

### **Албан шаардлага:**

1. Тайлант хугацааны эцэст байгууллагад өгөх 829.8 мянган төгрөгийн, хувь хүмүүст өгөх 159.5 мянган төгрөгийн өглөг, тээвэр шатахууны 1,074.7 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Мөн Нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлээгүйн улмаас 106.5 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

2. Шилэн дансны системд зарлагын 428.8 сая төгрөгийн 14 гүйлгээнээс 409.3 сая төгрөгийн 13 ажил гүйлгээг хугацаа хоцроосон, 19.5 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, хөрөнгө зарцуулах нийт 317.2 сая төгрөгийн 43 тушаал шийдвэрээс 202.3 сая төгрөгийн 31 тушаалыг хугацаа хоцроосон байна. Өмнөх онд зөвлөмж хүргүүлсэн ба тайлант онд зөрчил давтагдан гарсан.

### **Зөвлөмж:**

#### **1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Тус байгууллага нь тайлант хугацаанд цэвэр бохир усны зардалд нийт 10,282,800 төгрөг зарцуулсан ба 6 дугаар сард 6,946,580 төгрөг, 12 дугаар сард 3,614,160 төгрөгийг зарцуулсан байна.

#### **2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

Тайлант хугацааны эцэст тээвэр шатахууны зардлыг хэтрүүлэн, үүссэн өглөгийг илүү дүнгээр шилжүүлж 1,074.7 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

#### **3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Тус байгууллага нь байгууллагын удирдлагын шийдвэргүйгээр Өмч хамгаалах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн 6,593.3 мянган төгрөгийн аж ахуйн материал, 16,987.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, нийт акталж, данснаас хассан байна.

### **Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал**

Аудитаар нийт 24,071.0 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс 2,305.8 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад бүрэн залруулж, залруулагдаагүй 3 зөрчилд 2 албан шаардлага, 1 төлбөрийн акт өгөв.

### **Залруулсан алдаа:**

1. Хяналтын улсын байцаагчийн 2024.12.18-ны өдрийн №0705409 дүгээр шийтгэлийн хуудсаар тус байгууллагын дарга Б.Соёлсүрэнд Зөрчлийн тухай хуулийн 10.20-д заасны дагуу 500,000 төгрөгийн торгууль ногдуулсныг байгууллагын төсвөөс 300,000 төгрөг, төлсөн байна. Өглөгөөр тусгасан 200,000 төгрөгийг залруулсан.
2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн цалингийн зардлыг 1,198,092 төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 300,000 төгрөгөөр, үндсэн хөрөнгийн тодруулга тайланд хөрөнгийн элэгдлийг 507,747.15 төгрөгийн зөрүүтэй тайлагнасан, акталсан 100,000 төгрөгийн хөрөнгийг худалдан борлуулсан хөрөнгөөр тусгасан байна. аудитын хугацаанд 2,105,839.15 төгрөгийг залруулсан.

### **Албан шаардлага:**

1. Тайлант онд түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй олгосон тул нийгмийн даатгалын тайланд 1,573,786 төгрөгийг нөхөж тайлагнах.
2. ИТХ-ын өрөөний дотор засвар хийх" ажил гүйцэтгэх гэрээг Иргэн С.Оюунбаттай 2024.11.22-ны өдөр байгуулж, ажлын хөлсөнд 19,891,419 төгрөгийг шилжүүлж, засварын ажил хийгдэж эхлээгүй, ажлыг хүлээж аваагүй байхад шууд зардалд хаасан байна.

**Төлбөрийн акт:**

Хяналтын улсын байцаагчийн 2024.12.18-ны өдрийн №0705409 дүгээр шийтгэлийн хуудсаар тус байгууллагын дарга Б.Соёлсүрэнд Зөрчлийн тухай хуулийн 10.20-д заасны дагуу 500,000 төгрөгийн торгууль ногдуулсныг байгууллагын төсвөөс 300,000 төгрөгийг төлсөн байна.

**Хоршоо хөгжүүлэх сан:**

Аудитаар нийт 17,163.3 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс 16,660.8 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад бүрэн залруулж, залруулагдаагүй 1 зөрчилд албан шаардлага өгөв.

**Залруулсан алдаа:**

1. Тайлант онд үүссэн авлагын үлдэгдлийг 19,701 төгрөгөөр дутуу бүртгэсэн байсныг залруулсан.
2. Санхүүгийн тайланд тайлант үеийн үр дүнг 15,641,176.74 төгрөгөөр илүү бүртгэсэн байсныг залруулсан.

**Албан шаардлага:**

1. Хугацаа хэтэрсэн 5-н иргэний зээлийн үлдэгдэл 1,02,454 төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Мөн гэрээнд заасны дагуу төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

**Орон нутгийн хөгжлийн сан:**

Аудитаар нийт 699,693,221 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 666,693,211 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад бүрэн залруулж, залруулагдаагүй 3 зөрчилд 2 албан шаардлага, 1 төлбөрийн акт өгөв.

**Залруулсан алдаа:**

Тайлант онд сумын ОНХС-д 666,693,211 төгрөгийн эх үүсвэр баталсныг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаагүй байсныг залруулсан.

**Албан шаардлага:**

1. 2023 оноос үргэлжлэн хэрэгжүүлсэн 3 ТАХ-ны санхүүжилтийг 2024 оны сумын ИТХ-аар батлуулаагүй, 28,420,155 төгрөгийн санхүүжилт олгосон.
2. Шилэн дансны системд байршуулбал зохих 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын нийт 19 ажил гүйлгээ, 5 шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан байна.

**Төлбөрийн акт:**

1. Багш ажилчдын 4 айлын орон сууцны халаалт, цэвэр бохир усны холболтын зураг төслийн ажил гүйцэтгэх 1 ТАХ-д 4,367,266 төгрөгийг ОНХС-аас санхүүжүүлсэн байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 санхүүгийн тайлан дүгнэлт 4 санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан байна.

Нөхөн сэргээлтийн тусгай дансны санхүүгийн тайланг аудит хийх байгууллагын тоонд оруулж, аудит хийх хуваарь батлуулаагүй ба ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн хугацаанд аудитад хамруулж, шалгасан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 121.1 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрсэн. Аудитын явцад 121.1 сая төгрөгийн 5 алдааг бүрэн залруулга хийсэн.

### **Залруулга:**

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийг 6,422,555 төгрөгөөр дутуу тайлгазнасан байсныг залруулсан
2. Нэмэлт дансны төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлэг 26,688,667.32 төгрөг, урсгал засварын зардал 500,000 төгрөг, томилолтын зардал 5,940,000 төгрөг, нийт 33,128,667.32 төгрөгийг зардалд бүртгээгүй байсныг залруулсан.
3. Нэмэлт санхүүжилтийн дээд шатнаас олгосон санхүүжилтийг 8,595,616 төгрөгөөр орлогын ангилал буруу бүртгэсэн байсныг залруулсан.
4. Мөнгөн гүйлгээний тайланд засгийн газрын дотоод шимжүүлэг болон орон нутгийн төсөвт шилжүүлэх татаас 26,688,591 төгрөгийг зөрүүлж бүтгэсэн байсныг залруулсан.
5. Санхүүгийн үр дүнгийн тайланд тогтмол зардал 18,193,508 төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 4,941,000 төгрөгийг тус тус дутуу бараа үйлчилгээний зардал 23,134,507 төгрөгийг илүү бүртгэсэн байсныг залруулсан.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад  
талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ нэгтгэл тайлан	5	121,104.4	2	39,551.2	3	<b>81,553.2</b>	5	121,104.4	-	-
ЗДТГ	4	15,161.0	1	4,367.3	3	10,793.7	4	15,161.0	-	-
ИТХ	2	2,305.8			2	2,305.8	2	2,305.8	-	-
ОНХС									-	-
ХХС	2	15,660.8			2	15,660.8	2	15,660.8	-	-
НСС									-	-
<b>Дүн</b>	<b>13</b>	<b>154,232.0</b>	<b>3</b>	<b>43,918.5</b>	<b>10</b>	<b>110,223.5</b>	<b>13</b>	<b>154,232.0</b>	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТТЗ нэгтгэл тайлан										
ЗДТГ	3	26,825.5			1	2,170.5	2	24,655.0		
ИТХ	3	21,465.2	1	300.0	2	21,465.2	-	-		
ОНХС	2	32,787.4	1	4,367.3	1	28,420.1	-	-		
ХХС	1	1,502.4			1	1,502.4	-	-		
НСС							-	-		
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>82,580.5</b>	<b>2</b>		<b>5</b>	<b>53,558.2</b>	<b>2</b>	<b>24,655.0</b>		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
ЗДТГ	1	-			1					
ОНХС	1	-			1					
<b>Дүн</b>	<b>2</b>				<b>2</b>					
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
ЗДТГ	1	7,560.7					1	7,560.7		
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>7,560.7</b>					<b>1</b>	<b>7,560.7</b>		